МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 10 өдөр Дугаар А/395 Мөрөн сум

Цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/331 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум орон нутгийн хэмжээнд 2023 оны цэргийн бүртгэл зохион байгуулж явуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Цэргийн бүртгэлийг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хооронд "Цэргийн бүртгэл явуулах журам"-ын дагуу зохион байгуулж, холбогдох мэдээ, судалгаа, тайланг үнэн зөв гаргаж, 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ирүүлэхийг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

2. Цэргийн бүртгэлтэй холбогдуулан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, удирдлагаар ханган ажиллаж, аймгийн нэгдсэн дүн, мэдээг тогтоосон хугацаанд гаргаж Зэвсэгт хүчний жанжин штабт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (хурандаа С.Батхуяг)-д даалгасугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

671 011 012